

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Д/д	ТОДОРХОЙЛОЛТ	Ажил гүйцэтгэх талаар тодорхой санал ирүүлэх.
1. Байр-	1.1 Дорноговь, Дундговь аймгийн зарим бэлчээрийн талбайд газар доорх усны геофизикийн хайгуулын ажил гүйцэтгэж уст цэг тогтоох	
1.	1.2 Тухайн аймгийн хөдөөгийн хүн ам, мал аж ахуйг усаар хангах, бэлчээрийг усжуулах төлөвлөгөөтэй уялдуулах.	
2. Ажлын тодорхойлолт	2.1 Уст цэг тогтоох магадлал 0.7-оос дээш байна. Дараах шалгуур үзүүлэлтийг мөрдөнө. Үүнд:	
	2.2 <ul style="list-style-type: none"> - Магадлалын шалгуур нь гидрогеологийн ижил нөхцөлд байгаа уст цэгүүд дээр хэмжсэн параметрийн хэмжилт байх, - Газар доорх усны орон заин баиршлыг структурын хөндлөн чиглэлд доод тал нь нэг шугамаар тодорхойлох. - Хэмжилтийн цэг хоорондын зай нь голын хөндий, хоолойн өргөн, уст үеийн тархалт, зузаанаас хамааруулан сонгох. - Геофизикийн аргуудын үр дүнг харьцуулан дүгнэлт гаргах Геофизикийн хайгуулын ажлын дэс дараалал: <ul style="list-style-type: none"> - Бэлтгэл ажил - Урьдчилсан хайгуул /гидрогеологийн маршрутын мұдалгаа/, - ВЭЗ, ВЭП, - Соронзон хайгуул, радиометрийн хэмжилт /шаардлагатай нөхцөлд/ - Биолокацийн хайгуул - Газар доорх ус эрж хайдаг бусад орчин үеийн шинэлэг арга, технологи - Суурин боловсруулалт, Тайлан бичих, хамгаалах, гэрээг дүгнэх 	
	2.3 <ul style="list-style-type: none"> - Геофизикийн хайгуулын ажлыг гүйцэтгэхийн өмнө гидрологи, гидрогеологийн судалгааны материалыг ашиглана. Тухайлбал тухайн талбай дахь: - Ус хуримтлуулах талбайн хэмжээ хайгуул хийх газар тус бүрт бодох, - Тухайн газрын нийт ууршилтыг тооцох, - Гадаргын болон газар доорх усны нөөцийн прогноз өгөх, - Хайгуул хийгдэх талбайн ойр орчмын булаг, шанд, худгуудын ундарга, уст үеийн зузаан, шүүрэлтийн коэффициентийг тодорхойлох, - Гидрогеологийн параметруудийг тодорхойлж, гидрогеологийн нөхцлийг тодруулах. - хайгуул хийх газарт ус гарах магадлал багатай бол ойролцоох газарт хайгуулыг явуулж, газрын нэр солбилцлыг тодорхой бичнэ. 	
2.4 Хайгуулын ажлын бүрэлдэхүүн хэсэг: <ul style="list-style-type: none"> - Гидрогеологи, геофизик /гидрологи/ инженертэй байх - Оператор - Ажилчин 		